МОНГОЛ УЛС
# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 25 өдөр Дугаар А/36 Мандалговь

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай

Монгол улсын Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.12, Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолоор батлагдсан "Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журмын"-ын 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсан Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Өндөршил, Дэрэн, Гурвансайхан сумдын нутаг дэвсгэрт 2018 оны 01 сарын 25-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

Хоёр. Говь-Угтаал, Цагаандэлгэр, Өндөршил, Дэрэн сумдын шуудан тээвэр, Баянжаргалан, Өлзийт, Хулд, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдаас тээвэрлэж буй уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн хөдөлгөөн болон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг малын гоц халдварт шүлхий өвчин намдах хүртэл тодорхойгүй хугацаагаар хориглосугай.

Гурав. Сумдын удирдлагууд, малчид, ард иргэдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг ХХААГазар /Б.Мөнхжаргал/, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /Я.Алтанхундага/, Цагдаагийн газар /Н.Ганбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т тус тус даалгасугай.

Тав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/15 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ж.МӨНХЧУЛУУН

0220128